



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
 ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ
 ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
 ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
 ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
 ЗАСАГ ДАРГЫН
 ЗАХИРАМЖ**

2022 оны 07 сарын 26 өдөр

Дугаар А/464

Алтай хот


Захирамж хэсэгчлэн хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.3 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Алтай хотын инженерийн шугам сүлжээ бүхий бүсэд газар эзэмшиж байсан иргэн Г.Хишигхүү, Н.Батболд нарын хүсэлтийг үндэслэн аймгийн Засаг даргын 2018 оны А/02 дугаар захирамжийн хавсралтын 45 дугаарт, 2017 оны А/446 дугаар захирамжийн хавсралтын 1 дүгээрт бичигдсэн хэсгийг тус тус хүчингүй болгосугай.

2.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар (Н.Сумъяабазар), Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Д.Алтанзагас)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР